



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр


Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон АСБИ ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


Компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн
Хараат бус аудиторын тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

“АСБИ” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудиторын тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Д.ЛХАГВАСҮРЭН





“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэг, 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дор дурьдсан хүмүүсийг ажиллуулахаар баталсугай.

ТУЗ-ын ердийн гишүүнд

- 1.1 Д.Лхагвасүрэн
- 1.2 Л.Сүмбанд
- 1.3 Ч.Дашцэрэн
- 1.4 С.Буман-Эрдэнэ
- 1.5 Б.Доржсүрэн
- 1.6 Л.Түвшинзаяа


ТУЗ-ын хараат бус гишүүнд

- 1.7 Э.Буянтогтох
- 1.8 Ц.Хадаа
- 1.9 Л.Нямдаваа

2. Компанийн үр ашгийг дээшлүүлж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, менежментийг сайжруулах, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж, туслах чиглэлээр идэвхи гарган ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Д.ЛХАГВАСҮРЭН





“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсөв батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 62.1.15 дахь заалт, 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын 2020 оны төсвийг 7,000,000 /долоон сая/ төгрөгөөр тогтоосугай.
2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурал
хүчин төгөлдөр болсныг батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “АСБИ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчдээс 10 хувьцаа эзэмшигч онлайнгаар холбогдсон нь 61,001 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 96.1% болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН
ДАРГА

Б.ДОРЖСҮРЭН